



## Тусламжийн Тэргэнцэр Сан

### “ТЭРГЭНЦЭРИЙН ЗАМ” МОНИТОРИНГИЙН ТӨСӨЛ

Тусламжийн тэргэнцэр сан /ТББ/ нь 2000 оноос эхлэн өөрийн орны нуруу нугас, тулгуур эрхтний гэмтэл согогийн улмаас хөдөлгөөний үлэмж бэрхшээлтэй болсон иргэдэд АНУ-ын хүмүүнлэгийн байгууллагатай хамтран ажиллах замаар чанар, дизайн сайтай хүүхдийн болон насанд хүрэгчдэд зориулсан тэргэнцэр, төрөл бүрийн таяг, саажилттай хүүхдийг суулгах, зогсоож сургах төхөөрөмжүүд зэрэг бага оврын өдөр дутмын хэрэгцээний тоног хэрэгслийг шаардлагатай хүмүүст нь өгч туслах үйл ажиллагааг 8 дахь жилдээ эрхлэж байна. Энэ ажлын явцад бидний анхаарлыг татсан нэг зүйл бол тэргэнцэртэй хүн бусдын адил сурч боловсрох, ажил хөдөлмөр эрхлэх, нийгэм хамт олны дотор орж улс төр нийгмийн амьдралд тэгш оролцох эрхээ эдлэхэд хөрш зэргэлдээ орон, дэлхийн бусад улсад аль хэдийнээ тэргэнцэрт зориулсан зам, барилгад орж гарах налуу шат, бие засах зориулалтын кабин зэрэг архитектурын орон зайн төлөвлөлтийг төрийн бодлогын хэмжээнд шийдээд барилга байгууламжийн зураг төсөв зохиох, барьж байгуулах ажилд хэрэглэдэг болсон байхад манайх энэ талаар үлэмж хоцрогдсноо мэдэрсэн юм.

Тэргэнцэрийн зам бол түүнийг хэрэглэгч хүний хувьд тэдний амьдрах орчныг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөгөө эдлэх бололцоог олгох, амьдралынхаа чанарыг дээшлүүлэх хэрэгт юугаар ч орлуулашгүй хэрэгцээ нь болдог. Энэ байдлаас үндэслэж Тусламжийн тэргэнцэр сан 2002 онд “Тэргэнцэрийн зам” төсөл боловсруулан төр, засгийн холбогдох байгууллагуудад танилцуулан тэдний дэмжлэгийг авсны үр дүнд 2004 онд ШУТИС-ийн барилгын салбрын эрдэмтэдийн хүчээр боловсруулсан “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль” гэсэн /БД 31-101-04/ нормативын баримт бичиг батлагдан гарсан юм. Энэ бол Монголд анх удаа хийгдсэн ажил бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг шийдэх том гарц болж өгөв. Барилга байгууламжийг төлөвлөгч, зураг төсөл зохиогч, барьж босгох ажлыг эрлэдэг байгууллагын аль нь ч энэ талын туршлага хомс байсны дээр хүнд тохиолдсон бэрхшээл зовлонг хуваалцах хүмүүнлэг сэтгэл дутснаас ч юмуу эсвэл ихэнхдээ манай бүх шатанд хүний хөгжлийн дорой байдлаас шалтгаалж уг нормалийг хэрэгжүүлэх ажил удааширч байгаад дүгнэлт хийж “Тусламжийн тэргэнцэр сан” ННФ-ын тэтгэлгээр 2006 оны 11 сарын 25 - 12 сарын 25 хүртэл нэг сарын хугацаанд Нийслэл хот түүний дүүргүүдэд Улаанбаатар хотод оршин суудаг 2000 гаруй тэргэнцэртэй хүнд зориулж дээр дурьдсан орц гарц, зам ямар хэмжээнд хийгдэх байгаад хяналт-үнэлгээ өгөхийг зорьсон юм. Энэ ажлыг гүйцэтгэхэд зориулан гаргасан төсвийн дагуу сангийн 3 ажилтан, түр авч ажиллуулсан 4 хүн / үүний 2 нь архитектор / бүгд 7 хүний хүчээр Улаанбаатар хотын төв ба алслагдсан дүүргүүдэд орших засаг захиргаа, соёл боловсрол, эрүүл мэнд, худалдаа үйлчилгээ, тээвэр холбоо зэрэг төрийн ба төрийн үйлчилгээний байгууллагын эзэмшилд одоо ашиглаж байгаа 100 гаруй барилгад тэргэнцэртэй болон хараа, сонсгол муутай хүн орж гарах боломжийг хангахад чиглэсэн ямар нэг нэмэгдэл ажлыг / налуу зам, тусгай дохиолол тэмдэглээ / батлагдсан нормалийг үндэслэн хийж эхлэсэн эсэхийг газар дээр нь үзэхэд тэдгээрийн дөнгөж 12-т нь барилгад орж гарах налуу зам гаргасан боловч олонхи нь тэргэнцэртэй хүнд биш ачаа зөөх зориулалттай байлаа. Мониторинг хийсэн багийнхан уг барилга байшинг эзэмшигч хүмүүс, барилгын зураг төсөл зохиогчид, барилгын гүйцэтгэгч болон барилгын ажил эрхлэдэг төрийн яам, агентлагийн ажилтанууд, нийслэл хотын удирдлагатай уулзаж сонирхосон асуудлаараа ярилцаж, хяналт-үнэлгээ хийсэн объектуудынхаа зургийг авч баримтжуулан гүйцэтгэсэн ажлын тайланг гаргаж түүнд өөрсдийн үнэлэлт, дүгнэлтийг өгч санал зөвлөмжөө бичлээ.

Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль гарч батлагдаад 3 жил шахам болох хугацаанд Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалсан сонирхогч зарим байгууллага энэ асуудлаар тусгайлан сургалт зохион байгуулах, уулзалт-семинар хийх, олон нийтийн мэдээлэлийн хэрэгслээр сурталчлах зэргээр бага зэрэг дуулиан шуугиан үүсэгсэн боловч ажилд ахиц өөрчлөлт гарсангүй. Үүнтэй холбогдуулан төр засаг, иргэний нийгэм, олон нийтийн анхааралд хүрхүйц нөлөөлөлийн арга хэмжээ авах шаардлагатай байгааг харгалзан уг төслийн хүрээнд “Амьдралд хөтлөх зам” баримтат кино бүтээх ажлыг хийгээд дуусч байна. Үүний зэрэгцээ Мониторинг хийсэн дүнг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагуудын үндэсний холбоо, хүний эрхийн үндэсний комисс, Нийслэлийн захирагчийн албаны барилга, хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн газрын холбогдох хүмүүст танилцуулан асуудал тавьж цаашид авах арга хэмжээг төлөвлөх ажилд ороод байна.